



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2025 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.3 дахь хэсгийг үндэслэн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан “Боловсролыг дэмжих жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд дараах арга хэмжээг тусган хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т даалгасугай:

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын чиглэлээр:

1/багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих, мэргэшил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааг үндэсний болон олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаанд үндэслэн хөгжүүлж, багш бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх чиглэлээр багшийн хөгжлийн төвүүдийн үйл ажиллагааг тогтворжуулах;

2/бүх шатны сургуулийн бие даасан байдлыг хангаж, гүйцэтгэлийг сайжруулах хүрээнд боловсролын байгууллагын менежментийг боловсронгуй болгох цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх, захирал, удирдах ажилтныг бэлтгэх тогтолцоог нэвтрүүлэх;

3/сургуулийн хүчин чадлын талаар хийсэн судалгаанд үндэслэн анги дүүргэлт, нэг сургуульд суралцах хүүхдийн тоог зохих норм нормативт нийцүүлэх, шинээр барих, сургуулийн барилгын хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар сургалтын чанарыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үе шаттай арга хэмжээ авах;

4/багшлах хүний нөөцийн дутагдлын талаар хийсэн судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн 2030 онд мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн эзлэх хувийг 96 хувьд хүргэх, багш бэлтгэдэг дээд боловсролын сургалтын байгууллагын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, зээл, тэтгэлгээр суралцсан суралцагчийн гэрээний биелэлтэд дүгнэлт хийж, төгсөөд багш мэргэжлээрээ ажиллагсдыг 60 хувиар нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;

5/ерөнхий боловсролын сургуулийн гуравдугаар ангиас эхлэн англи хэл сургах болсонтой холбогдуулан стандартад нийцсэн сурах бичгээр хангах, багшлах хүний нөөцийг чадавхжуулах, сургалтын хэрэглэгдэхүүн, дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах арга хэмжээг шуурхай авч, сургалтын хөтөлбөрийг чанартай хэрэгжүүлэх;

6/хос хэлний боловсрол, сургалтын талаар баримтлах чиглэлийн хэрэгжилтийг эрчимжүүлж, казах, тува суралцагчид хос хэлээр суралцах, цөөнх доторх цөөнх халх, урианхай суралцагчдад эх хэлээрээ бага боловсрол эзэмших боломжийг бүрдүүлж, ном, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнээр бүрэн хангахад анхаарч ажиллах;

7/ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт хиймэл оюун ухааны хичээлийн агуулгыг тусгах, багш нарын чадавхыг дээшлүүлэх;

8/Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх”, “монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжлийг олгох” зорилтыг ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлд иж бүрэн, боловсролын түвшин хоорондын залгамж холбоотой байхаар тусган хэрэгжүүлэх.

Мэргэжлийн болон техникийн боловсролын чиглэлээр:

9/мэргэжлийн болон техникийн боловсролын тогтолцоонд төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогыг үндэсний болон олон улсын түвшинд өргөжүүлж, олон талт санхүүгийн эх үүсвэрийг бий болгох замаар хамтарсан сургалт, үйлдвэрлэл, судалгааны төв байгуулж, сургалтын орчин, дэд бүтцийг шинэчлэх;

10/бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх зорилгоор бүс бүрд технологийн коллеж /Коосэн сургууль/ байгуулах судалгааг эрчимжүүлж, өмнө байгуулагдсан технологийн коллежуудаас туршлага судалж, хамтарч ажиллах;

11/хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ур чадварын зөрүүг судалгаанд тулгуурлан тогтоож, аж ахуйн нэгжүүдийн оролцоонд суурилсан ажил мэргэжлийн стандарт болон сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг хэрэгжүүлж, иргэд ажиллангаа суралцах, суралцангаа ажиллах боломжийг нэмэгдүүлэх, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагуудын чанарын менежментийн чадавхыг бэхжүүлэх;

12/эрдэм шинжилгээ, судалгааны лаборатори, чадамжийн болон инновацийн төвүүдийг үе шаттайгаар байгуулах, туршилт судалгаанд суурилсан шинэ технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, сургалтын үйл ажиллагааг өргөжүүлэх замаар үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжиж, бүтээмжийг нэмэгдүүлэх;

13/Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2 дахь заалтад тусгагдсан мэргэжлийн өөрийн өртөгт суурилсан санхүүжилтийг нэвтрүүлэх.

Түр болон богино хугацааны сургалтын чиглэлээр:

14/мэргэжлийн сургалт /богино хугацааны/-ын байгууллагын бүртгэл, хяналт, багш бэлтгэх, үнэлэх, гэрчилгээжүүлэх тогтолцоог боловсронгуй болгож, судалгаа, арга зүйн төвүүдийг бүсчлэн байгуулж, удирдлагын тогтолцоог сайжруулан, мэргэжлийн сургалтын хамрах хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх.

Дээд боловсролын чиглэлээр:

15/дээд боловсролын сургалтын байгууллагын засаглалын бие даасан, үр дүнтэй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх;

16/төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад төрөөс олгох татаас дэмжлэгийг бодитоор нэмэгдүүлэх, технологийн тэргүүлэх чиглэлийн лаборатори, судалгааны тоног төхөөрөмжөөр хангах, ашиглалтын гэрээ хийх;

17/дээд боловсролын сургалтын байгууллагын багш, судлаачдын чадавхыг олон улсын түвшинд хүргэх, сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх;

18/дэлхийн шилдэг их сургуулийн зэрэглэлийн жагсаалтад эхний 50-д багтсан сургуулиас өндөр ур чадвартай багш, мэргэжилтнийг урьж ажиллуулах үйл ажиллагааг бодлогоор дэмжих;

19/дээд боловсролын сургалтын байгууллагын тодорхой хөтөлбөрүүдийг олон улсын магадлан итгэмжлэлд хамруулж, суралцагчид олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дипломтой төгсөх нөхцөлийг бүрдүүлэх;

20/төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын байгалийн ухааны хөтөлбөрийн сургалтын 10 хүртэлх хувийг англи хэлээр зохион байгуулах бэлтгэл ажлыг эрчимжүүлэх;

21/дээд боловсролын сургалтын байгууллагад бэлтгэх суралцагчдын хяналтын тоог хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээтэй уялдуулан тогтоох нийлүүлэлтийн цахим системийг хөгжүүлж, сургалтын бодлого төлөвлөлтөд нэвтрүүлэх;

22/боловсролын зээлийн санг Боловсролын хөгжлийн сан болгон өөрчилж, олон талт эх үүсвэрийн санхүүжилтийн тогтолцоог бий болгож, гадаад, дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагч, багш, судлаачид санхүүгийн дэмжлэг үзүүлэх, гадны өндөр зэрэглэлийн их сургуулиас зочин багш урьж ажиллуулах, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулан эрэлттэй болон тэргүүлэх чиглэлээрх суралцагчдын тоог нэмэгдүүлэх;

23/дээд боловсролын сургалтын байгууллагад зээл, тэтгэлгээр суралцаж төгссөн төгсөгчдийн гэрээний үүргийн хэрэгжилтийн хяналтыг сайжруулж, зээлийн эргэн төлөлтийг нэмэгдүүлэх.

2.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, насан туршийн суралцахуйн төвүүдийн багш, ажилтны цалингийн бүтцийг оновчтой болгох, цалин хөлсийг үе шаттайгаар нэмэгдүүлэх бодлогыг тогтвортой хэрэгжүүлэх.

3.Багш нарын нийгмийн баталгааг хангах зорилгоор “Төрийн албан хаагчийн орон сууц”, “Түрээсийн орон сууц”, “Ипотекийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт” зэрэг хөтөлбөрүүдэд нэн тэргүүнд багш нарыг хамруулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх.

4.Бүх шатны сургалтын байгууллагад холбогдох стандартын шаардлагад нийцсэн хүртээмжтэй орчныг бий болгох, сургалтын хэрэглэгдэхүүн, туслах технологийн хүртээмжийг сайжруулах, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажиллах багш, туслах багш бэлтгэхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх, багш бэлтгэдэг дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөрт ялгаатай хэрэгцээтэй суралцагчтай ажиллах агуулгыг тусгах.

5.Дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад бэлтгэгддэггүй ортопед, протезийн их эмч, мэргэжилтэн, техникч, хэл засалч зэрэг эрэлттэй мэргэжлээр гадаад улсад диплом, бакалаврын хөтөлбөрт суралцуулахыг дэмжих.

6.Боловсролын тэгш бус байдал, чанарын ялгааг арилгах, цахим шилжилтийг дэмжих зорилгоор боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, ширээ сандал, тавилга, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж, багш, сурагч бүрийг компьютержуулах үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн санхүүгийн боломжит арга механизмыг ашиглан зохион байгуулах.

7.НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилт болон боловсролын салбарын стратегийн зорилттой уялдуулан боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын бүтцэд мэргэжлийн боловсрол, ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн сурч боловсрох эрхийг хангах чиг үүрэг бүхий тэгш хамран сургах боловсролын асуудал хариуцсан нэгжийг тус тус сэргээн байгуулах.

8.Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар (Г.Занданшатар)-т үүрэг болгосугай.

9.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо (Б.Найдалаа)-нд даалгасугай.

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.НАЙДАЛАА

